



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 63

Сүхбаатар сум

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг  
эрчимжүүлэх тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 36 дугаар тогтоолоор бэлчээр тариалангийн болон хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах асуудлыг судлах зорилго бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсоод ТЭМДЭГЛЭХ нь:

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд малын тоо толгой хэт өссөнөөс бэлчээрийн даац хэтэрч бэлчээрийн газрын доройтол эрчимтэй явагдаж байна. Аймгийн хэмжээнд бэлчээрийн даацын судалгааг сум бүрээр гаргахад нийт сумдад малын хэт өсөлтөөс шалтгаалан бэлчээрийн даацын хэмжээ 2,5-3,9 дахин нэмэгдсэн байна.

Бэлчээрийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж хадлангийн болон тариалангийн талбай малын бэлчээр болон хувирч улмаар тариалангийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөн зөвхөн 2016-2017 онд нийт 23,1 мянган га талбайд мал орж 4368,5 тн ургацын хохирол учирч, 400 гаруй сая төгрөгийн нөхөн төлбөрийг малчид хүлээсэн байна. Тариалангийн талбайг малын хөлөөс хамгаалах зорилгоор сумдад 51,4 мянган га талбайг хамгаалахаар нийтдээ 1258 км хашаа барьж, энэ арга хэмжээнд тариаланчид 2,5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Цаашид бэлчээр, хадлангийн болон тариалангийн талбайн хөрсний элэгдэл доройтлыг бууруулах, үржил шимийг хамгаалах зорилгоор малын тоо толгойг цөөрүүлэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулан эрчимжүүлж, бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуйг хөгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”,

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-ийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Засаг дарга \Ш.Оргил\-д ДААЛГАХ нь:

а) Бэлчээр, хадлангийн талбайн доройтлыг бууруулах хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор мал бүхий иргэд, аж ахуй нэгжүүдээс нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийг Засгийн газрын 2018 оны "Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 182 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу тухайн газрын тогтоосон суурь үнэлгээний 0,03 хувиар ногдуулан авах ажлыг эрчимжүүлэх;

б) Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэн бэлчээр ашигласны төлбөрийг бэлчээр хадлангийн талбайг нөхөн сэргээх, ашиглалтыг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зэрэг ажил арга хэмжээнд зарцуулах;

Хоёр. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь заалтыг хэрэгжүүлэн нутаг дэвсгэртээ бэлчээрийн газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Г. БЯМБАА

